



ХУУЛЬ ЗҮЙН  
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

ТЭСЭРЧ ДЭЛБЭРЭХ БОДИС , ТЭСЭЛГЭЭНИЙ ХЭРЭГСЛИЙН  
ЭРГЭЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН  
ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ

**2018**

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

## **ТЭСЭРЧ ДЭЛБЭРЭХ БОДИС, ТЭСЭЛГЭЭНИЙ ХЭРЭГСЛИЙН ЭРГЭЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ<sup>1</sup>**

### **УДИРТГАЛ**

Монгол Улс зах зээлийн харилцаанд шилжиж, төрийн өмчийн үйлдвэрүүдийн бүтэц задарч, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд бий болж, эдийн засаг нийгмийн хөгжлийн түлхэц болсон уул уурхайн салбар хурдацтай хөгжиж, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлт нэмэгдсэнээр хэрэглээ эмх замбараагүй болж зөрчил, гэмт хэргийн гаралт нэмэгдэх болов. Ийнхүү уг харилцаанд хяналт тавих эрх зүйн орчинг шинээр бүрдүүлэх цаг үеийн хэрэгцээ, шаардлагаар Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийг анх 2004 онд баталсан.

Уул уурхайн салбар улам эрчимтэй хөгжиж ашигт малтмалын томоохон ордууд эдийн засгийн эргэлтэд орсноор тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн үйлдвэрлэл, хэрэгцээ, импорт эрс нэмэгдсэн. Үүнтэй уялдуулан аж ахуйн зарим үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой харилцааг зохицуулах, онцгой аюултай тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэлд тавих төрийн хяналтыг сайжруулах шаардлага зүй ёсоор тавигдаж Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийг 2013 онд дахин шинэчлэн баталжээ.

“Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 152-т Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг санаачлан боловсруулна гэж төлөвлөсөн. Мөн Хууль зүй, дотоод хэргийн яамны 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 1.1.15-д тус хуулийн төслийн үзэл баримтлалыг батлуулах, 2018 онд хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тусгажээ.

Иймд Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээг хийв.

### **НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ**

#### **1.1. Үнэлгээ хийх үндэслэл, шаардлага**

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлд “Монгол Улсын иргэн дараах эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ.” гээд тус зүйлийн 1 дэх хэсгийн 2-т “эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй.” гэж, Арван есдүгээр зүйлийн 1-д “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж, мөн зүйлийн 2-т “Хүний эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй” гэж тус тус заасан.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 51.3-т “хуульд өөрөөр заагаагүй бол хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийнэ” гэж заасан.

Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль /цаашид ТДБТХЭХТТХ гэх/-ийг хэрэгжсэнээс хойш 14 жилийн хугацаанд нийт

<sup>1</sup> Тус судалгааг Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, хууль зүйн доктор, дэд профессор П.Амаржаргал удирдан, эрдэм шинжилгээний ажилтан Д.Цэцэгдарь, Ж.Ариунцэцэг, Б.Алтангэрэл нар хамтран гүйцэтгэв.

2 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.<sup>2</sup>

Ийнхүү тэсэрч дэлбэрэх бодисын хяналтыг зохицуулах эрх зүйн орчин шинэчлэгдэн сайжирсан хэдий ч тус хуулийн хэрэгжилтийн байдлаас үзэхэд тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн үйлдвэрлэл, ашиглалт, хадгалалт, тээвэрлэлт хяналтын зохицуулалтыг боловсронгуй болгох, зарим нэг салбарын хуулийн шинэчлэлтэй холбогдуулан хууль хоорондын зөрчлийг арилгах шаардлага байсаар байна.

ТДБТХЭХТТХ нь тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтийн хяналтад бодит хувь нэмэр оруулсан бөгөөд тэсэлгээний хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх болон аюулгүй ажиллагааны хүрээнд мэдэгдэхүйц дэвшилтийг авчирсан. Гэсэн хэдий ч хэрэгжиж эхэлснээс хойш 5 жилийн хугацаанд энэ хуулийн хэрэгжилтийн үр нөлөө харьцангуй тодорхой болж, практикт хэрхэн хэрэгжиж байгааг гүнзгийрүүлэн судлах, тулгамдаж буй асуудлыг тодорхойлон шийдвэрлэх арга замыг эрэлхийлэх нь зүйтэй байна.

Уг үнэлгээгээр Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудал, хэрэгжилтийн хувьд үр нөлөө тааруу байгаа зүйл, заалтыг тодруулах зорилгоор тохирох шалгуур үзүүлэлтээр үнэлгээ хийсэн болно.

### **1.2. Үнэлгээ хийх хүрээ**

Үнэлгээ хийх хүрээг тогтоох үүднээс ТДБТХЭХТТХ-ийн үйлчлэлд хамаарах төрийн байгууллагын төлөөллөөс ганцаарчилсан ярилцлага авсан бөгөөд оролцсон субъектүүд энэхүү хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах зарим санал илэрхийлсэн болно.<sup>3</sup>

Үнэлгээг хууль сахиулах байгууллагын тэсэрч дэлбэрэх бодисын эргэлтэд тавих хяналтын асуудлын хүрээнд гүйцэтгэв. Үүнд:

1. Пиротехникийн хэрэгслийн талаарх зохицуулалт;
2. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хууль сахиулах байгууллагын тавих хяналтын асуудал гэсэн хүрээг сонгосон болно.

### **1.3. Үнэлгээний шалгуур үзүүлэлт**

1.3.1. Пиротехникийн хэрэгслийн талаарх зохицуулалтын хүрээнд “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл

ТДБТХЭХТТХ-ийг анх баталснаас хойш, пиротехникийн хэрэгслийг импортлох, ашиглах асуудал тус хуулийн 17.1-д заасны дагуу тусгай дүрмээр зохицуулагдсаар иржээ.

Пиротехникийн хэрэгслийг үйлдвэрлэх, импортлох, ашиглах хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох талаар хуульд заагаагүй ч өнөөгийн практикт мэргэжлийн зөвлөлийн санал дүгнэлтийг үндэслэн Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас зөвшөөрөл олгож байна.<sup>4</sup>

<sup>2</sup> Энэ хуульд 2015, 2017 онд тус бүр нэг удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. Эдгээр нэмэлт, өөрчлөлтүүд нь уг хуулийн агуулга, үзэл баримтлалыг үндсээр нь өөрчлөхөд чиглэсэн бус 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт тус тус өөрчлөлт оруулжээ.

<sup>3</sup> 2018 оны 1 дүгээр сарын 15-ны өдөр Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Уул уурхай бодлогын газрын ахлах мэргэжилтэн Т.Зууннаст, тус яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн Б.Дашбал нартай хийсэн ярилцлага.

<sup>4</sup> ТДБТХЭХТТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал.

Өөрөөр хэлбэл, пиротехникийн хэрэгслийг тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслээс ялгаатай байхаар хуульд заасан боловч түүнийг үйлдвэрлэх, импортлох, ашиглах этгээд нь хэн байх, хаанаас ямар зөвшөөрөл авахыг тодорхойгүй тул холбогдох дүрмээр<sup>5</sup> энэ эрхийг хувь хүнд ч олгож болохоор байна.

Олон нийтийн аюулгүй байдлыг хангах, иргэдийн болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх, пиротехникийн хэрэгслийг худалдах, ашиглахтай холбоотой зохицуулалт сул байгаа нь практикт хүндрэл, бэрхшээл үүсгэж байна.

Сонгосон зохицуулалтыг практикт нийцсэн байдлыг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэх бөгөөд шаардлагатай гэж үзвэл зөвлөмж, санал боловсруулна.

Энэ хүрээнд сонгосон зүйл, заалтыг хүснэгтээр үзүүлбэл:

***Хүснэгт 1. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, заалт***

| № | Сонгосон зүйл, заалт   | Зүйл, заалтын агуулга                                                                                           |
|---|------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------|
|   | 17 дугаар зүйлийн 17.1 | Пиротехникийн хэрэгсэл<br>17.1. Пиротехникийн хэрэгслийг импортлох, ашиглах асуудлыг тусгай дүрмээр зохицуулна. |

1.1.2. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хууль сахиулах байгууллагын тавих хяналтын хүрээнд “Хүлээн зөвшөөрөгдсөн байдал” шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл:

Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтийн асуудлаар мэргэжлийн санал, дүгнэлт, зөвлөмж гаргах үүрэг бүхий Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны дэргэд төрийн бус байгууллага болон холбогдох төрийн байгууллагыг төлөөлсөн мэргэжилтнүүдээс бүрдсэн “Мэргэжлийн зөвлөл” ажиллаж байна. Зөвлөл байгуулагдсанаар зөвлөлийн бүрэлдэхүүнд байгаа байгууллагуудын харилцаа, хамтын ажиллагаа, уялдаа холбоо, хяналтын тогтолцоог бүрдүүлэх үндсэн суурь бүрдсэн байна.

Зөвлөлийн бүрэлдэхүүнд уул уурхай болон батлан хамгаалах асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, ашигт малтмал, мэргэжлийн хяналт, тагнуул, зэвсэгт хүчин, цагдаа болон онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, холбогдох их, дээд сургууль, мэргэжлийн холбоодын төлөөлөл<sup>6</sup> байдаг бөгөөд уг төлөөлөл /Мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн<sup>7</sup>/-ийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд томилдог.

Гэсэн хэдий ч өнөөдрийн практикт мэргэжлийн зөвлөлийн төлөөллийг томилохдоо ямар шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгож ажиллуулж байгаа нь тодорхой бус, уг асуудлын талаар ТДБТХЭХТТХ-д<sup>8</sup> болон Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн асуудлаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий мэргэжлийн зөвлөлийн дүрэм<sup>9</sup>-д тусгаагүй байна.

Иймд мэргэжлийн зөвлөлийн төлөөллийг томилохдоо шударга, нээлттэй, үр дүнтэй байгаа эсэх, зөвлөлийн үйл ажиллагааны зарчим бодитойгоор, хэрхэн

<sup>5</sup> Монгол Улсын Засгийн газрын 2006 оны 149 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт, дам ишлэв. ТДБТХЭХТТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал.

<sup>6</sup> “Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн асуудлаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий мэргэжлийн зөвлөлийн дүрэм” Засгийн газрын 2013 оны 139 дүгээр тогтоолын хавсралт.

<sup>7</sup> Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2016 оны 9 дүгээр сарын 12-ны өдрийн 22 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт.

<sup>8</sup> Төрийн мэдээлэл эмхэтгэл №8, 2013 он, Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль /Шинэчилсэн найруулга/ 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэгт.

<sup>9</sup> Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн асуудлаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий мэргэжлийн зөвлөлийн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэгт.

хэрэгжиж буй практик, хууль сахиулах байгууллагын тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд тавих хяналт болон мэдээллийн нэгдсэн сангийн хүлээн зөвшөөрөгдсөн байдлыг авч үзэх нь зүйтэй юм.

Энэ хүрээнд сонгосон зүйл, заалтыг хүснэгтээр үзүүлбэл:

**Хүснэгт 2. “Хүлээн зөвшөөрөгдсөн байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, заалт**

| №  | Сонгосон зүйл, заалт               | Зүйл, заалтын агуулга                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                     |
|----|------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1. | 23 дугаар зүйлийн 23.4, 23.5       | Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд тавих хяналт<br>23.4.Мэргэжлийн зөвлөлийн гишүүн нь хууль бусаар бусад гишүүндээ нөлөөлөхийг хориглоно.<br>23.5.Мэргэжлийн зөвлөлийн гишүүн нь төрийн байгууллагыг төлөөлөн албан үүргээ хэрэгжүүлэх үед хувийн ашиг сонирхлыг нийтийн ашиг сонирхлоос дээгүүр тавихгүй.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                           |
| 2. | 22 дугаар зүйлийн 22.1, 22.2, 22.4 | Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн мэдээллийн нэгдсэн сан<br>22.1.Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хуулийн этгээдэд хадгалагдаж байгаа болон үйлдвэрлэсэн, импортолсон, экспортолсон, худалдсан, ашигласан, устгасан тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн нэр төрөл, тоо ширхэг, байршлыг нарийвчлан тусгасан мэдээллийн нэгдсэн сантай байна.<br>22.2.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн мэдээллийн нэгдсэн сангийн хөрөнгийн эх үүсвэрийг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний төсвийн багцаас санхүүжүүлнэ.<br>22.4.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн мэдээллийн нэгдсэн сантай холбогдолтой мэдээллийг батлан хамгаалахын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, мэргэжлийн хяналтын төв байгууллага, гамшгаас хамгаалах байгууллага, цагдаагийн болон тагнуулын байгууллага авч ашиглана. |

**1.4. Үнэлгээний арга зүй**

Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ыг баримтлан гүйцэтгэв.

Үнэлгээнд хараат бус, бие даасан байдлаар гүйцэтгэх шинжлэх ухааны арга зүйг баримтлан, баримт бичиг судлах арга болон ярилцлагын аргыг ашигласан бөгөөд үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийг зөвхөн тухайн үнэлгээгээр тогтоосон үр дүнд үндэслэсэн болно.

| №  | Үнэлгээний хүрээ                                                                                | Сонгосон зүйл, заалт                                                                                  | Шалгуур үзүүлэлт              | Харьцуулах хэлбэр                                    |
|----|-------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------|------------------------------------------------------|
| 1. | Пиротехникийн хэрэгслийн талаарх зохицуулалт                                                    | 17 дугаар зүйл. Пиротехникийн хэрэгсэл 17.1                                                           | Практикт нийцэж байгаа байдал | Байх ёстой болон одоо байгаа                         |
| 2. | Хууль сахиулах байгууллагын тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд тавих хяналт | 22 дугаар зүйл. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн мэдээллийн нэгдсэн сан 22.1, 22.2, 22.4 | Хүлээн зөвшөөрөгдсөн байдал   | Хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш |

**ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ**

2.1. Пиротехникийн хэрэгслийн талаарх зохицуулалт: “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

Үнэлгээний энэ хэсэгт пиротехникийн хэрэгслийн талаарх зохицуулалттай холбоотой үүсч буй хүндрэл, бэрхшээлийг “Практикт нийцэж байгаа байдал”

шалгуур үзүүлэлтийн хүрээнд тодруулан, холбогдох зүйл, заалтын хэрэгжилтийг үнэлэв.

**Хуулийн 17 дугаар зүйл. Пиротехникийн хэрэгсэл**

17.1.Пиротехникийн хэрэгслийг импортлох, ашиглах асуудлыг тусгай дүрмээр зохицуулна.

Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 4.1.3- т “пиротехникийн хэрэгсэл” гэж хурц гэрэл гэгээ цацруулдаг буюу чанга дуу чимээ үүсгэдэг баяр ёслол, үзвэр, цэнгээний зориулалтаар ашиглагдах хэрэгслийг ойлгоно гэж заасан.

Одоогийн байдлаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам нь пиротехникийн хэрэгслийг тэсэрч, дэлбэрэх бодистой адилтган үзэж импортлох, худалдах зөвшөөрөл 2, ашиглах зөвшөөрөл 1-ийг тус тус олгосон байна.<sup>10</sup>

Зөрчлийн тухай хуулийн 5.14 дүгээр зүйлийн 6 дахь хэсэгт зааснаар шатамхай бодис, эсхүл пиротехникийн эдлэхүүнийг ашиглах журам зөрчсөн бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгохоор зохицуулсан.

Нийслэлийн Засаг даргын 2016 оны “Хууль ёс, дэг журам, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” 03 дугаар албан даалгавар, Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын “Шалгалт зохион байгуулах тухай” А/89 дүгээр тушаалыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд тус газрын гал түймрийн улсын хяналтын байцаагч, гал түймэр унтраах, аврах ангиудын салааны захирагч нар хамтран нийслэлийн нутаг дэвсгэрт шинэ жилийн баяр тэмдэглэх, хүлээн авалт зохион байгуулах, аж ахуйн нэгж, иргэдийн барилга байгууламжийн галын аюулгүй байдал, үзвэр үйлчилгээ, томоохон худалдааны төвүүдэд пиротехникийн хэрэгсэл худалдан борлуулж байгаа байдалд хяналт шалгалтын ажлыг 2016 оны 12 дугаар сарын 12-ны өдрөөс эхлүүлэн ажилласан байна. Шалгалтын ажлын хэсгээс нийт 278 объектыг шалгаж, худалдааны төв, зах, нийтийн эзэмшлийн талбайд шинэ жилийн тоглоом хэрэгсэл, худалдан борлуулж буй иргэдээс нийт 16 пиротехникийн хэрэгсэл, бенгалын гал 500 ш, диманик 200 ш, оргилуур салют 55 ширхгийг тус тус хураан авч, 3 субъектийг 550.000 төгрөгөөр торгож захиргааны арга хэмжээ тооцож ажиллажээ.<sup>11</sup>

Өнгөрсөн онд Нийслэлийн Онцгой байдлын газраас нийслэлийн 9 дүүргийн нутаг дэвсгэрт байршилтай нийт 425 объектыг шалгаж, галын аюулгүй байдлын норм дүрэм, стандарт зөрчсөн 1049 зөрчил илрүүлэн гал түймрийн улсын хяналтын байцаагчийн 121 заавал биелүүлэх албан шаардлага, 144 мэдэгдэл, 6 танилцуулга, 11 дүгнэлтийг байгууллагын шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтанд хүргүүлж хэрэгжилтэд нь хяналт тавин ажилласан байна.<sup>12</sup>

Засгийн газрын 149 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар Пиротехникийн хэрэгслийг импортлох, ашиглах дүрэм

Энэхүү дүрэм нь пиротехникийн хэрэгслийг импортлох, хадгалах, худалдах, тээвэрлэх харилцаа болон тэдгээртэй холбоотой аюулгүй ажиллагааны горимыг зохицуулдаг. Тус дүрэмд заасны дагуу пиротехникийн хэрэгслийг аюул учруулах зайгаар нь ангилна. Пиротехникийн хэрэгсэл нь 20 метрээс их зайд аюул учруулах хүч чадалтай бол үзвэрийн ангилалд, 20 метрээс бага зайд аюул учруулах хүч чадалтай бол хэрэглээний ангилалд хамруулдаг.

<sup>10</sup> ТДБТХЭТТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал.

<sup>11</sup> Пиротехникийн хэрэгслийн аюулгүй байдлын хяналт шалгалт үргэлжилж байна. <http://nobg.ub.gov.mn/?p=7445> (сүүлд үзсэн 2018.08.10)

<sup>12</sup> Пиротехникийн хэрэгслийн аюулгүй байдлын хяналт шалгалт явагдаж байна. [http://www.control.mn/i/13805#.W5OF\\_egzYdU](http://www.control.mn/i/13805#.W5OF_egzYdU) (сүүлд үзсэн 2018.08.10)

Уг дүрэмд пиротехникийн хэрэгсэл импортлох, бөөнөөр худалдах аж ахуйн нэгж, байгууллага, иргэн нь тухайн хэрэгслийн зориулалт, тоо хэмжээ, хадгалах, тээвэрлэх нөхцөл зэргийг тодорхой заасан өргөдлийг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргаж бүртгүүлэхээр заасан. Мөн пиротехникийн хэрэгслийг жижиглэн худалдах аж ахуйн нэгж, байгууллага, иргэн нь тухайн нутаг дэвсгэрийн мэргэжлийн хяналтын байгууллагад бүртгүүлсэн байна.

Пиротехникийн хэрэгслийг үзвэрийн зориулалтаар ашиглах аж ахуйн нэгж, байгууллага, иргэн тухайн нутаг дэвсгэрийн цагдаагийн болон онцгой байдлын байгууллагад үзвэр зохион байгуулахаас 3-аас доошгүй хоногийн өмнө бүртгүүлэх ёстой.

Нийслэлийн Засаг даргын 2009 оны 662 дугаар захирамж:

Энэхүү захирамжаар нийслэлийн нутаг дэвсгэрт соёл урлаг, худалдаа, үзвэр үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн барилга, байгууламж дотор пиротехникийн хэрэгслийг ашиглан салют, гэрэлт үзүүлбэр зохион байгуулахыг хориглосон.

Нийслэлийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2011 оны 27 дугаар тогтоол:

Энэхүү тогтоолд “Төрийн захиргааны байгууллагуудын байр, соёл, боловсрол, эрүүл мэндийн байгууллага, гэр хороолол, нийтийн эзэмшлийн орон сууц, түүний ойр орчинд, барилгын зорийн давхар, задгай талбай, худалдааны төв, хүнс, барааны зах, болон гар дээрээс пиротехникийн хэрэгслийг худалдахгүй, ашиглахгүй байх”-аар зохицуулсан.

Ялангуяа, шинэ жилийн баярын үеэр олон нийтийн аюулгүй байдлыг хангах, иргэдийг болзошгүй аюулаас урьдчилсан сэргийлэх арга хэмжээ жил бүр зохион байгуулах шаардлагатай болдог.

Мөн пиротехникийн хэрэгсэл худалдан борлуулдаг аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавьж, худалдааны төв, зах, дэлгүүр, гудамж талбайд тавих хяналтыг эрчимжүүлэх шаардлага гардаг байна.

Нийслэлд пиротехникийн хэрэгслийг худалдах зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж нь пиротехникийн хэрэгслийг худалдсан тохиолдолд мэргэжлийн операторчноор буудлага хийлгэх журамтай.

Олон нийтийн аюулгүй байдлыг хангах, иргэдийг болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх, баярын арга хэмжээг зөв зохистой тэмдэглэн өнгөрүүлэх зорилгоор Нийслэлийн Цагдаагийн газраас “Пиротехникийн хэрэгсэл” арга хэмжээг зохион байгуулж эхэлжээ. Иргэдэд протехникийн хэрэгсэл буюу салютыг хувь хүний гар дээрээс худалдан авахгүй байх, зөвшөөрөлтэй газраас нь худалдан авч мэргэжлийн хүмүүсээр буудлага хийлгүүлэх хэрэгтэйг анхааруулсан байна.<sup>13</sup>

Пиротехникийн хэрэгсэл (бенгалын гал, салют, г.м) нь тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл багагүй хэмжээгээр агуулдаг ба үүнээс үүдэлтэй эрсдэл үүслээ гэхэд учруулж болох хохирлын хэмжээ багагүй байна. Эдгээр бүтээгдэхүүнийг импортлох худалдан борлуулах үйл ажиллагааг Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн хүрээнд Уул уурхайн яамнаас тусгай зөвшөөрөл олгосон аж ахуй нэгж худалдан борлуулдаг хэдий ч хүмүүсийн, тэр дундаа өсвөр үеийнхний түүнтэй харьцах, өөрийгөө хамгаалах мэдлэг хангалтгүй байгаагаас бэртэж гэмтсэн тохиолдол нэлээдгүй гарсан байдаг.<sup>14</sup>

<sup>13</sup> Пиротехникийн хэрэгсэл арга хэмжээ үргэлжилж байна. <http://old.eagle.mn/content/read/10133.htm> (сүүлд үзсэн 2018.07.25).

<sup>14</sup> Тэсэрч дэлбэрэх бодисын хэрэглээнд тулгамдаж буй зарим асуудал” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл; 2015 он, УБ.,

Пиротехникийн хэрэгслийг тусгай зөвшөөрлөөр олгоно гэсэн хууль, эрх зүйн зохицуулалт байдаггүй. Пиротехникийн хэрэгслийг импортлох, ашиглах дүрэм батлагдсан. Яг тусгай зөвшөөрөлтэй байна гэснийг зохицуулаагүй. Зарим компаниуд ямар ч байсан албан ёсны бичиг баримттай байх нь зөв гээд ирээд авсан компани байна.<sup>15</sup>

Тэсэлгээний зөвшөөрөлгүй компани, хувиараа ашигт малтмал олборлогч иргэд тэсрэх материалыг ашиглах сонирхол их байгаагаас тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл хулгайлах, хууль бусаар борлуулах, тэсэлгээ хийх, мөн иргэд баяр ёслол тэмдэглэх зорилгоор пиротехникийн хэрэгсэл ашиглах, хилээр хууль бусаар нэвтрүүлэх, зөвшөөрөлгүйгээр гар дээрээс худалдаалах зэрэг зөрчил, гэмт хэргийн гаралт төдийлөн буурахгүй байна.<sup>16</sup>

Дээр дурдсанаас үзэхэд ч пиротехникийн хэрэгслийг импортлох, ашиглахад тавих шаардлагыг хуульчлах нь зүйтэй байна.

2.2. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хууль сахиулах байгууллагын тавих хяналт: “Хүлээн зөвшөөрөгдсөн байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн дагуу УУЯ, ТЕГ, ЦЕГ, МХЕГ, ЗХЖШ, ОБЕГ, АМГ, ШУТИС болон мэргэжлийн холбоо, судалгаа, шинжилгээний байгууллагын төлөөлөл оролцсон 15 хүний бүрэлдэхүүнтэй Мэргэжлийн зөвлөл ажиллаж байна.<sup>17</sup> Уг зөвлөлийн ажиллах журам<sup>18</sup>-ыг 2016 онд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд баталсан.

Мэргэжлийн зөвлөлийн үндсэн үйл ажиллагаа нь хуулийн этгээдийн бүрдүүлсэн бичиг баримтыг хүлээн авах, гишүүдэд танилцуулах, холбогдох байгууллагын саналыг авах, Зөвлөлийн хурлыг зохион байгуулах, хурлын албан ёсны санал, дүгнэлт, зөвлөмжийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдад танилцуулж холбогдох шийдвэр гаргуулахад чиглэгдэнэ.<sup>19</sup>

Өөрөөр хэлбэл, хууль сахиулах байгууллагаас хэрэгжүүлэх хяналтын нэг хэлбэр нь тэдгээрийн Мэргэжлийн зөвлөл дэх оролцоо болж байна. Тус зөвлөлөөс гаргаж буй санал, дүгнэлт, зөвлөмж нь хараат бус, бие даасан, холбогдох хууль тогтоомжид бүрэн нийцсэн байх ёстой.

Мэргэжлийн зөвлөл нь тэсэлгээ хийдэг аж ахуйн нэгжүүдэд тусгай зөвшөөрөл олгох, импортлох, үйлдвэрлэх, үйл ажиллагаанд нь хяналт тавих, үйл ажиллагаанд нь мэргэжлийн зөвлөгөө өгөх үүрэгтэй ажилладаг. Харин тэсэрч, дэлбэрэх бодисын ашиглалт, хэрэглээ болон газар нутагтаа тэсэлгээг зөв хийж байгаа эсэхэд МХЕГ-аас хяналт тавих үүрэгтэй.<sup>20</sup>

ТЕГ-аас ирүүлсэн саналд “Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтийн асуудлаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий Мэргэжлийн зөвлөл ажиллаж эхэлснээр аж ахуйн нэгжүүдэд тусгай зөвшөөрөл шинээр нэмж олгох, хугацааг дахин сунгах асуудалд тус зөвлөлийн гишүүд өөрсдийн чиглэлийн дагуу хяналт тавин ажиллаж, хуулийн шаардлага хангаж *ажиллахгүй* байгаа аж ахуйн нэгжүүдийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох, шинээр тусгай зөвшөөрөл олгох

<sup>15</sup> 2018 оны 1 дүгээр сарын 15-ны өдөр Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн Б.Дашбалтай хийсэн ярилцлага.

<sup>16</sup> ТДБТХЭХТТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал.

<sup>17</sup> ТЕГ-ын 2017 оны 12 дугаар сарын 28-ны 01/1652 дугаартай албан бичиг.

<sup>18</sup> Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2016 оны 9 дүгээр сарын 12-ны өдрийн 22 дугаар тушаалын 2 дугаар хавсралт. “Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтийн асуудлаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий Мэргэжлийн зөвлөлийн ажиллах журам”

<sup>19</sup> Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2016 оны 9 дүгээр сарын 12-ны өдрийн 22 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт. “Мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн”

<sup>20</sup> Тэсэрч дэлбэрэх бодисын хэрэглээнд тулгамдаж буй зарим асуудал” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл; 187 дахь тал, 2015 он, УБ.,

асуудлыг багасгасан”<sup>21</sup> гэж үзсэн.

Мөн тус байгууллагаас ирүүлсэн албан бичигт тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл импортлох, ашиглах, худалдах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагууд дараах нийтлэг зөрчил, дутагдлыг гаргадаг гэжээ.<sup>22</sup>

Үүнд:

- Тэсэлгээний ажлыг зөвшөөрөлгүй хийх;
- Тэсрэх материалыг хууль бусаар худалдах;
- Тэсрэх материал ашиглах, шаардлага хангаагүй агуулах, саванд хадгалах;
- Зориулалтын бус тээврийн хэрэгслээр тээвэрлэх;
- Зарцуулалтын тайлан хөтлөхгүй байх;
- Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэлтэй харьцаж байгаа хүмүүсийг

даатгалд хамруулахгүй байх зэрэг нийтлэг зөрчил, дутагдал багтаж байна.

Эдгээр зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хянах чиглэлээр ТДБТХЭХТТХ-ийн холбогдох зохицуулалтыг хэрэгжүүлэх чиг үүргийг Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Батлан хамгаалах яам, Онцгой байдлын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар, Дотоодын цэрэг, Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтийн асуудлаар мэргэжлийн санал, дүгнэлт, зөвлөмж гаргах үүрэг бүхий мэргэжлийн зөвлөл зэрэг байгууллага хэрэгжүүлж ажилладаг.

ТДБТХЭХТТХ-ийн 23.1-т “Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль тогтоомжийн биелэлтэд мэргэжлийн хяналтын байгууллага хяналт тавьж ажиллана” гэсэн нь цагдаагийн байгууллагаас тавих хяналтын хүрээг хязгаарласан заалт хэмээн үзэж байна.<sup>23</sup>

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон хууль хяналтын байгууллагууд энэ төрлийн бодисыг үйлдвэрлэдэг, импортолдог, ашигладаг аж ахуйн нэгжүүд болон тэдгээрийн харуул хамгаалалтын үйл ажиллагаанд тавих хяналтаа сайжруулахгүй бол нийгэмд айдас төрүүлэхүйц, олныг цочроосон гэмт хэрэг, терроризмын шинжийг агуулсан халдлага гарахгүй гэсэн баталгаа байхгүй байна.

Монгол Улсын хэмжээнд “Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох, худалдах, тэсэлгээний ажил үйлчилгээ хийх” тусгай зөвшөөрөл бүхий нийт 64 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байгаагаас гадаадын хөрөнгө оруулалттай 7, дотоодын хөрөнгө оруулалттай 46, хамтарсан хөрөнгө оруулалттай 11 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна.<sup>24</sup>

ТДБТХЭХТТХ-ийн 18.3-т заасны дагуу батлагдсан “Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-ийн 4 дүгээр хавсралтын дагуу тэсрэх материалын агуулахад оруулж гаргаж байгаа тэсрэх материалын бүртгэлийг хөтлөх үүрэгтэй.

Мөн тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа аж ахуйн нэгжүүд нь ТДБТХЭХТТХ, Гэрээт харуул хамгаалалтын тухай хууль, “Тэсэлгээний аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм” зэрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангалтгүй биелүүлж байгаагаас гадна тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн аюулгүй байдлыг хангах, бүртгэл судалгаа, гэмт халдлагаас урьдчилан сэргийлэх ажил огт хийгээгүй, гамшгаас хамгаалах төлөвлөгөө, гамшгийн эрсдэлийн үнэлгээ, агуулахын зураг төсөл хийгээгүй, нэр төдий байна.<sup>25</sup> Тэсрэх материалын агуулахын харуул

<sup>21</sup> ТЕГ-ын 2017 оны 12 дугаар сарын 28-ны 01/1652 дугаартай албан бичиг.

<sup>22</sup> ТЕГ-ын 2017 оны 12 дугаар сарын 28-ны 01/1652 дугаартай албан бичиг.

<sup>23</sup> “Тэсэрч дэлбэрэх бодисын хэрэглээ түүнд тавигдах шаардлага” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл. 26 дахь тал, 2014 он, УБ.,

<sup>24</sup> Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэлтэй холбоотой хууль, эрх зүйн орчин, хэрэгжилт. <http://www.mnb.mn/i/142993> (сүүлд үзсэн 2018.07.25).

<sup>25</sup> ТЕГ-ын 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 01/1652 дугаартай албан бичиг.

хамгаалалтыг хариуцан ажиллаж байгаа гэрээт харуул хамгаалалтын байгууллагууд нь хамгаалагч нараа мэргэжлийн сургалтад хамруулаагүй, хамгаалагч нар зориулалтын бус хувцастай үүрэг гүйцэтгэж, аюултай бүсэд гадны хүн нэвтрэх, бүртгэл судалгааг хэрхэн явуулах талаар мэдэгдэхүүнгүй байна.<sup>26</sup>

Уул уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй боловч тэсэлгээний тусгай зөвшөөрөлгүй компаниуд болон хувиараа ашигт малтмал олборлогч иргэд тэсрэх материал ашиглах сонирхол их байгаагаас хууль бус эргэлт нэмэгдэх, улмаар энэ төрлийн хууль бус наймаа эрхлэгчдийг өөгшүүлснээр үйл ажиллагаа нь зохион байгуулалтад орж, улам бүр далд хэлбэрт шилжин, зам суваг улам нарийсаж байгаа нь харагдаж байна. Мөн хууль, хүчний байгууллагаас тэсрэх материалын хууль бус эргэлтэд тавих хяналтыг сайжруулж тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлснээр тэсрэх материал хууль бусаар зарж борлуулдаг, ашигладаг этгээдүүдийг хяналтад авч ажиллаж байна. ТДБТХЭХТТХ-д импортолсон болон үйлдвэрлэсэн тэсрэх бодис бүр дугаартай байх, тэсрэх материалын эргэлтийн мэдээллийн нэгдсэн сантай байхаар заасан боловч өнөөг хүртэл уг хуулийн зохицуулалт хэрэгжихгүй байгаа нь тэсрэх материалын хууль бус эргэлтэд сөргөөр нөлөөлж байна.<sup>27</sup>

2017 оны байдлаар Монгол Улсад үйлдвэрлэлийн зориулалтаар тэсэлгээний ажил, үйлчилгээ үзүүлэх, тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл импортлох, үйлдвэрлэх, худалдах тусгай зөвшөөрөлтэй нийт 60 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна. Үүнд, гадаадын 100 хувийн хөрөнгө оруулалттай 7, дотоодын 100 хувийн хөрөнгө оруулалттай 42, хамтарсан хөрөнгө оруулалттай 11 аж ахуйн нэгж байна.<sup>28</sup>

Мэдээллийн сан:

ТДБТХЭХТТХ-ийн 4.1.7-д “мэдээллийн нэгдсэн сан” гэж төрийн захиргааны байгууллага болон хуулийн этгээдээс энэ хуульд заасны дагуу ирүүлсэн тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтийн талаарх мэдээ мэдээлэл, тайлангийн нэгтгэлийг ойлгоно.

Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хуулийн этгээдэд хадгалагдаж байгаа болон үйлдвэрлэсэн, импортолсон, экспортолсон, худалдсан, ашигласан, устгасан тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн нэр төрөл, тоо ширхэг, байршлыг нарийвчлан тусгасан мэдээллийн нэгдсэн сантай байна.<sup>29</sup>

ТДБТХЭХТТХ-д “Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг зөвшөөрөгдсөн чиглэлийн дагуу тээврийн стандартыг баримтлан тусгай тоноглогсон тээврийн хэрэгслээр аюулгүй байдлыг хангаж, харуул хамгаалалттай тээвэрлэх бөгөөд тээврийн хэрэгслийн зөвшөөрөл, тээвэрлэлтийн маршрут, харуул хамгаалалтыг цагдаагийн байгууллага олгож, аюулгүй байдалд хяналт тавина”<sup>30</sup> гэж хуульчилсан.

Энэ хүрээнд төрийн захиргааны эрх бүхий байгууллага /яам/-аас тэсэлгээний ажил гүйцэтгэх, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг үйлдвэрлэх, импортлох, экспортлох, худалдах, тэсэлгээний ажил, үйлчилгээ үзүүлэх тусгай

<sup>26</sup> Мөн тэнд.

<sup>27</sup> Мөн тэнд.

<sup>28</sup> Мөн тэнд.

<sup>29</sup> Төрийн мэдээлэл эмхэтгэл №8, 2013 он, Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль /Шинэчилсэн найруулга/ 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэгт.

<sup>30</sup> Төрийн мэдээлэл эмхэтгэл №8, 2013 он, Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль /Шинэчилсэн найруулга/ 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт.

зөвшөөрлийг хуульд заасны дагуу авсан аж ахуйн нэгж, байгууллагад тээврийн хэрэгслийн зөвшөөрөл, тээвэрлэлтийн маршрут олгох үйл ажиллагааг хөнгөвчлөх, олон шат дамжлагыг багасгаж, төрийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй хүргэх, нөгөө талаар тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэх, тухайн бодисын эргэлтэд болон тухайн үйл ажиллагааг эрхлэгч байгууллагуудын үйл ажиллагаанд болон аюулгүй байдалд хяналт тавих зорилгоор “Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтийн бүртгэлийн програм хангамж”-ийг боловсруулж нэвтрүүлээд байна.

Хуулийн этгээд тус програмд [www.eis.police.gov.mn](http://www.eis.police.gov.mn) цахим хаягаар хандаж, өөрийн нэгжийн тухай мэдээллийг санд бүртгүүлснээр тээврийн хэрэгслийн болон маршрутын зөвшөөрөл авах эрхтэй юм.<sup>31</sup>

ТДБТХЭХТТХ-ийн 22 дугаар зүйлийн холбогдох хэсэг хэрэгжихгүй байна. Тодруулбал, **Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн** мэдээлэлд нэвтрэх боломж байхгүй тул хяналт бүрэн хэрэгжих боломжгүй байдаг байна. Тус хуулийн хүрээнд хууль сахиулах байгууллагаас хэрэгжүүлэх хяналт нь иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг гажуудуулахгүй байх зорилгыг хангах ёстой. Гэвч тэсэлгээний ажил зөвшөөрөлгүй хийх, тэсрэх материалыг хууль бусаар худалдах, ашиглах, шаардлага хангаагүй агуулах, саванд хадгалах, зориулалтын бус тээврийн хэрэгслээр тээвэрлэх, зарцуулалтын тайлан хөтлөхгүй байх, ажилчдыг зохих даатгалд хамруулахгүй байх зэрэг зөрчил түгээмэл байна.<sup>32</sup>

Түүнчлэн тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд нь хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхгүй, үйл ажиллагааныхаа талаар зохих журмын дагуу цаг хугацаандаа тайлагнахгүй байх зэргээр хариуцлагагүй хандах нь нийтлэг байна. Тухайлбал: Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2016 онд тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл бүхий 5 хуулийн этгээдэд шалгалт хийхэд үйлдвэрийн байр, агуулахад гамшгийн эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээ хийлгээгүй, аюулгүйн бүс тогтоолгоогүй, зориулалтын агуулах, ачиж буулгах тусгай тоног төхөөрөмж, дотоодын тээврийн хэрэгсэлгүй зэрэг зөрчил илэрсэн бол 2017 оны шалгалтад хамрагдсан тэсэлгээний ажил эрхэлж байгаа 13 хуулийн этгээдийн хувьд тогтоосон хугацаанд мэдээ, тайланг ирүүлдэггүй, мөн дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтангүй, хяналтыг зохион байгуулах журамгүй үйл ажиллагаа явуулж байсан байна.<sup>33</sup>

Уул уурхайн ашиглалтын лицензтэй боловч тэсэлгээний тусгай зөвшөөрөлгүй компани, хувиараа ашигт малтмал олборлогч иргэд тэсрэх материалыг ашиглах сонирхол их байгаагаас хууль бус эргэлт нэмэгдэхийн зэрэгцээ тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл хулгайлах, хууль бусаар борлуулах, тэсэлгээ хийх, мөн иргэд баяр ёслол тэмдэглэх зорилгоор пиротехникийн хэрэгсэл ашиглах, хилээр хууль бусаар нэвтрүүлэх, зөвшөөрөлгүйгээр гар дээрээс худалдаалах зэрэг зөрчил, гэмт хэргийн гаралт буурахгүй байна. Энэ төрлийн зөрчил, гэмт хэргийн улмаас хүний эрүүл мэнд, амь нас хохирсон тохиолдол мөн цөөнгүй байна. Тухайлбал, энэ төрлийн гэмт хэрэг 2013 онд 48, 2014 онд 61, 2015 онд 48, 2016 онд 29, 2017 оны эхний 9 сарын байдлаар 21 бүртгэгдсэн байна.<sup>34</sup>

<sup>31</sup> Мэдээлэл, технологийн төвийн мэдээ. <http://ict.police.gov.mn/news/content/id/706/type/78> (сүүлд үзсэн 2018.07.25).

<sup>32</sup> ТДБТХЭХТТХ-ийн хэрэгжилтийн талаар 2017 онд Мэргэжлийн зөвлөлийн хийсэн шалгалтын зөвлөмж, дам ишлэв. ТДБТХЭХТТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал.

<sup>33</sup> Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын статистик бүртгэл, 2017 дам ишлэв. ТДБТХЭХТТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал.

<sup>34</sup> ЦЕГ-ын 2017 оны статистик мэдээлэл дам ишлэв. ТДБТХЭХТТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал.

Гамшгаас хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хураагдсан тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг мэргэжлийн байгууллагын хяналтын дор тэсэлгээний ажил явуулах эрх бүхий байгууллагад худалдах буюу шинэчилж сэлгэн сольж байршуулж болох ба энэ тухайгаа ТДБТХЭХТТХ-ийн 22 дугаар зүйлд заасан нэгдсэн мэдээллийн санд тухай бүр мэдэгдэх ёстой.

“Хуулийн этгээд нь тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн орлого, зарлага, үлдэгдлийн бүртгэлийг тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрмийн дагуу хөтөлж, улирал тутам тооллого явуулна”<sup>35</sup> гэж заасныг уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагууд бодитой хэрэгжүүлж байгаа эсэх нь эргэлзээтэй байна. Төрийн байгууллагуудын хооронд тэсрэх бодис, тэсэлгээний материалтай холбоотой мэдээллийн санг ашиглах байдал хангалтгүй байна. Цагдаа, тагнуул, мэргэжлийн хяналт, онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагуудын дүн мэдээ зөрдөг, мэдээ, тайланг харилцан солилцох тогтолцоо сайн бүрдээгүй байна.<sup>36</sup>

Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн мэдээллийн сан бүрдүүлэх APPS програм хангамжид 2017 оны эхний хагас жилийн байдлаар, Улсын хэмжээнд тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл импортлох, худалдаалах, үйлдвэрлэх, тэсэлгээний ажил, үйлчилгээ явуулах тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагаас 78 аж ахуйн нэгж, байгууллагын мэдээллийг цахим санд бүртгэсэн байна.<sup>37</sup>

Цаашид Монгол Улсад уул уурхайн салбар улам эрчимтэй хөгжиж ашигт малтмалын томоохон ордууд эдийн засгийн эргэлтэд орсноор тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн хэрэглээг даган үйлдвэрлэл, импорт нэмэгдэхээр байна. Тэсэрч дэлбэрэх бодисын ашиглалт, хадгалалт, тээвэрлэлтийн хяналтыг улам чангатгах, тэсэрч, дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг ашиглаж байгаа аж ахуй нэгжүүд нь тэсрэх материалыг үйлдвэрлэсэн, ашигласан талаарх мэдээ, тайлангаа хуулийн хугацаанд холбогдох байгууллагуудад өгөх, мэдээллийн санг ашиглалтад оруулах шаардлага тулгарч байна.

## **ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ**

### **3.1. Үнэлэлт, дүгнэлт**

Үнэлгээний ажилд сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу дараах дүгнэлтийг хүргүүлж байна.

Пиротехникийн хэрэгслийн талаарх зохицуулалтын тухайд “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Пиротехникийн хэрэгслийг импортлох, хадгалах, худалдах, тээвэрлэх харилцаа болон тэдгээртэй холбогдох аюулгүй ажиллагааны горимын хэрэгжилт хангалтгүй байна. ТДБТХЭХТТХ батлагдахаас өмнө пиротехникийн хэрэгслийг практикт бүрэн ашиглаж байсан зэрэг бэрхшээл өнөө хэр шийдвэрлэгдээгүй байгаа зэргээс харж болохоор байна.

Хүлээн зөвшөөрөгдөх байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд пиротехникийн хэрэгслийг ашиглах явцад тавих хяналт сул байгаа нь ажиглагдав.

<sup>35</sup> Төрийн мэдээлэл эмхэтгэл №8, 2013 он, Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль /Шинэчилсэн найруулга/ 18 дугаар зүйлийн 18.3 хэсэгт

<sup>36</sup> Тэсэрч дэлбэрэх бодисын хэрэглээнд тулгамдаж буй зарим асуудал” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл; 35 дахь тал, 2015 он, УБ.,

<sup>37</sup> Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн бүртгэлийн мэдээллийн сан бүрдүүлэх чиглэлээр. <http://www.police.gov.mn/a/3547> (сүүлд үзсэн 2018.07.25).

Пиротехникийн хэрэгслийг тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслээс ялгаатай байхаар хуульд заасан боловч түүнийг үйлдвэрлэх, импортлох, ашиглах этгээд нь хэн байх, хаанаас ямар зөвшөөрөл авахыг тодорхойлоогүй тул холбогдох дүрмээр<sup>38</sup> энэхүү эрхийг хувь хүнд ч олгож болохоор байна.

Түүнчлэн пиротехникийн хэрэгслийг импортлох, хадгалах, худалдах, тээвэрлэх явцад холбогдох субъектүүдийн эрх үүрэг тодорхой бус, тэнцвэртэй тогтолцоо бүрдээгүй зэрэг нь нийгэм дэх хүлээн зөвшөөрөгдсөн байдлын үнэлгээ хангалтгүй гарахад нөлөөлсөн гэж үзэж байна.

Энэ хүрээнд ашиглалтын пиротехникийн хэрэгслийг ашиглах тусгай зөвшөөрлийг зөвхөн хуулийн этгээдэд олгох, иргэн болон аж ахуй нэгжид хэрэглээний пиротехникийн хэрэгслийг ямар нэгэн болзолгүйгээр ашиглуулах гэсэн саналыг дэвшүүлж байна.<sup>39</sup>

Хууль сахиулах байгууллагын тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд тавих хяналтын тухайд “Хүлээн зөвшөөрөгдсөн байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Хууль сахиулах байгууллагын тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд тавих хяналт хангалттай бус байна.

Мэргэжлийн зөвлөлийн үйл ажиллагааг үр нөлөөтэй, бодитой хэрэгжих нөхцөлийг бүрдүүлснээр холбогдох дүрмийн хэрэгжих түвшинг дээшлүүлэх боломжтой.

Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн асуудлаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий мэргэжлийн зөвлөлийн төлөөллийг томилохдоо мэргэжлийн зөвлөлд ажиллах шалгуурыг тодорхойлох шаардлагатай.

Өнөөдөр Улсын хэмжээнд тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэлтэй холбоотой мэдээллийн нэгдсэн сангийн тусгайлсан ажиллагаа дутагдалтай, аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллагуудад тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хяналт, бүртгэл тооцоо дутагдалтай, мэдээлэл харилцан солилцох тогтолцоо бүрэн хэмжээгээр бүрдээгүй, хязгаарлагдмал байна.<sup>40</sup>

Дээрх нөхцөл байдлаас дүгнэхэд хууль сахиулах байгууллагуудын статистик мэдээ хоорондоо харилцан зөрүүтэй байдаг ба мэдээллийг солилцох тогтолцоо нийгмийн харилцааны түвшинг ханган ажиллаж чадахгүй байна гэж дүгнэж болохоор байна. Иймд тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд тавих төрийн хяналт, бүртгэл тооцоо, судалгаа, мэдээлэл солилцох үйл ажиллагааг боловсронгуй болгох, хууль сахиулах байгууллагуудын хяналт, хамтын ажиллагааг шинэчлэх, уялдаа холбоотой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, тэсэрч, дэлбэрэх бодис тэсэлгээний хэрэгслийг ашиглаж байгаа аж ахуй нэгжүүд мэдээ, тайлангаа хуульд заасан хугацаанд Уул уурхайн төрийн захиргааны төв байгууллага болон цагдаа, тагнуулын байгууллагад хүргүүлэх хэрэгцээ, шаардлага тулгарч байна.

### 3.2. Зөвлөмж

Үнэлгээний ажилд сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

Пиротехникийн хэрэгслийн талаарх зохицуулалтын тухайд “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

<sup>38</sup> Монгол Улсын Засгийн газрын 2006 оны 149 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт, дам ишлэв. ТДБТХЭХТТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал.

<sup>39</sup> Энэ санал ТДБТХЭХТТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн танилцуулгатай давхцаж байна.

<sup>40</sup> “Тэсэрч дэлбэрэх бодисын хэрэглээнд тулгамдаж буй зарим асуудал” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл 163 дахь тал, 2015 он.,

Пиротехникийн хэрэгслийг үйлдвэрлэх, импортлох, ашиглахад тавих шаардлагыг хуульчлах;

Стандарт, заавар, шаардлагыг тодорхой болгосноор зохицуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр илүүтэй анхаарах нь зүйтэй. Тухайлбал: Зааврыг Монгол хэл дээр орчуулж тухайн бүтээгдэхүүн дээр наасан байх шаардлагыг хэрэгжүүлэх боломжтой. Энэ хүрээнд гаалийн хяналт, шалгалтыг боловсронгуй болгох, уялдуулах шаардлагатай болно;

Хууль сахиулах байгууллагын тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд тавих хяналтын тухайд “Хүлээн зөвшөөрөгдсөн байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн ашиглалт, хяналттай холбоотой харилцааг зохицуулах нарийвчилсан дүрэм, журам батлах эрх шилжүүлсэн зохицуулалтыг Захиргааны ерөнхий хуультай нийцүүлэн тодорхой хуульчлах;

Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн асуудлаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий мэргэжлийн зөвлөлийн төлөөллийг томилохдоо тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн чиглэлээр мэргэшсэн байх, магистраас доошгүй зэрэгтэй, мэргэжилтэн ба түүнээс дээш албан тушаал эрхэлдэг байх гэсэн шаардлагыг хуульчлах;

Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл импортлох, ашиглах үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуй нэгж, байгууллагын тэсэлгээний сургалт төгссөн талаарх бүртгэл судалгааг авах;

Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд тавих хяналтыг сайжруулах, хууль хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий цагдаагийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх;

Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний бодисын эргэлт, хэрэгцээнд энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж, байгууллагын хариуцлагыг өндөржүүлэх, харуул хамгаалалтын үйл ажиллагааны нэгдсэн стандарттай болох шаардлагатай;

Хууль сахиулах байгууллагууд ажлын уялдаа холбоогоо сайжруулан тэсрэх бодис, тэсэлгээний материалтай холбоотой мэдээ, тайланг мэдээллийн сангийн цахим сүлжээг ашиглан хуульд заасан хугацаанд оруулж байх;

Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг ашиглаж байгаа аж ахуй нэгжүүд тэсрэх материалын үйлдвэрлэсэн, ашигласан талаарх мэдээ, тайланг хуульд заасан хугацаанд холбогдох байгууллагад хүргүүлж, мэдээллийн санг ашиглалтад оруулах тухай зөвлөмж тус тус багтана.

**АШИГЛАСАН МАТЕРИАЛ****Хууль тогтоомж, дүрэм журам**

- Гэрээт харуул хамгаалалтын тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл №4, 2000 он;
- Зөрчлийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл №24, 2017 он;
- Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл №1, 1992 он;
- Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл №8, 2013 он;
- Засгийн газрын 2006 оны 149 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт “Пиротехникийн хэрэгслийг импортлох, ашиглах дүрэм”;
- Засгийн газрын 2013 оны 139 дүгээр тогтоолын хавсралт “Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн асуудлаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий мэргэжлийн зөвлөлийн дүрэм”;
- Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2016 оны 22 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт “Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтийн асуудлаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий Мэргэжлийн зөвлөлийн ажиллах журам, бүрэлдэхүүн батлах тухай”;
- Цагдаагийн ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга нарын хамтарсан 2015 оны А/32/231 дүгээр тушаалаар баталсан “Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тээвэрлэлтийн үед мөрдөх аюулгүй ажиллагааны журам”;
- Нийслэлийн Засаг даргын 2009 оны 662 дугаар захирамж;
- Нийслэлийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2011 оны 27 дугаар тогтоол.

**Бусад эх сурвалж**

- ТДБТХЭХТТХ-ийн хэрэгжилтийн талаар 2017 онд Мэргэжлийн зөвлөлийн хийсэн шалгалтын зөвлөмж;
- ТДБТХЭХТТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал;
- “Тэсэрч дэлбэрэх бодисын хэрэглээ түүнд тавигдах шаардлага” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл; 2014 он, УБ.,
- Тэсэрч дэлбэрэх бодисын хэрэглээнд тулгамдаж буй зарим асуудал” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл; 2015 он, УБ.,
- ТЕГ-ын 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 01/1652 дугаартай албан бичиг;
- ЦЕГ-ын 2017 оны статистик мэдээлэл.

**Цахим эх сурвалж**

- Мэдээлэл, технологийн төвийн мэдээ.  
<http://ict.police.gov.mn/news/content/id/706/type/78>
- Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн бүртгэлийн мэдээллийн сан бүрдүүлэх чиглэлээр.  
<http://www.police.gov.mn/a/3547>
- Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэлтэй холбоотой хууль, эрх зүйн орчин, хэрэгжилт.  
<http://www.mnb.mn/i/142993>
- Пиротехникийн хэрэгслийн аюулгүй байдлын хяналт шалгалт явагдаж байна.  
[http://www.control.mn/i/13805#.W5OF\\_egzYdU](http://www.control.mn/i/13805#.W5OF_egzYdU) (сүүлд үзсэн 2018.08.10)
- “Пиротехникийн хэрэгсэл” арга хэмжээ үргэлжилж байна.  
<http://old.eagle.mn/content/read/10133.htm>